



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А1195

Улаанбаатар хот

Автомашины засвар үйлчилгээний
газруудад үзлэг шалгалт
зохион байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит 25 дугаар чуулганы хуралдааны 08 дугаар тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж, орон сууцны орчинд явган хүний зам талбайг хааж, автомашины зорчих, орц гарцын хэсэгт, саад болохуйц үйл ажиллагаа явуулж байгаа зориулалтын зогсоол, талбайгүй, зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа автомашины засвар үйлчилгээний газруудад, холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийн байдалд үзлэг шалгалт явуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Дүүрэг тус бүрт дараах бүрэлдэхүүний төлөөллийг оролцуулан байгуулахыг дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын орлогч бөгөөд Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөлийн дарга

Гишүүд: Нийтийн тээврийн үйлчилгээний газар
Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
Нийслэлийн 9 дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс
Нийслэлийн 9 дүүргийн Цагдаагийн хэлтэс

Нийслэлийн 9 дүүргийн Онцгой байдлын хэлтэс

Нийслэлийн 9 дүүргийн Газар зохион байгуулалтын алба

Нийслэлийн 9 дүүргийн Татварын хэлтэс

Нийслэлийн 9 дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэс

Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга

Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Тушаалын 1 дүгээр зүйлд заасны дагуу “Автомашинь засвар үйлчилгээний үйл ажиллагаанд үзлэг шалгалт зохион байгуулах” нэгдсэн удирдамж боловсруулан, удирдлагаар ханган ажиллахыг Нийтийн тээврийн үйлчилгээний газар /Ч.Сайханбаяр/-т, удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулж, 2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор нэгдсэн дүн, тайлан болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Нийтийн тээврийн үйлчилгээний газарт хүргүүлэхийг Ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Дүүргүүдийн Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг нэгтгэн 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийтийн тээврийн үйлчилгээний газар /Ч.Сайханбаяр/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

